



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2023 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 09/05

Хөхбүрд

Г Хүүхдийн төлөө зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын ээлжит есдүгээр хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1.Сумын хэмжээнд хүүхэд эрүүл аюулгүй орчинд өсөж бойжих, амьдрах, хөгжих эрхээ эдлэх, хүүхдийн эрхийг хангах, гэмт хэрэг, зөрчил, хүчирхийллийн аливаа хэлбэрээс бие махбодийн шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдлаас хамгаалагдах, хуулийг олон нийтэд сурталчлан таниулах үүрэг бүхий Хүүхдийн төлөө зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн ахлагчаар Засаг дарга

Гишүүдэд

Засаг даргын Тамгын газрын дарга

Эрүүл мэндийн төвийн дарга

Соёлын төвийн эрхлэгч

Цэцэрлэгийн эрхлэгч


Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга-Сургуулийн захирал

2.Хүүхдийн төлөө зөвлөлийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг сумын Засаг даргад, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажил, арга хэмжээний санхүүгийн эх үүсвэрийг төлөвлөн төсөвт тусгуулах ажлын тайланг жил бүр хуралдаанд танилцуулж үнэлэлт дүгнэлт гаргуулан ажиллахыг нарийн бичгийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Нийгэм цахим бодлогын хөгжлийн хороонд даалгасугай.

ДАРГА  Б.ОТГОНБАЯР



648801035